



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/204

Арвайхээр

Г Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, Г өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай” 147 дугаар тогтоолын нэгдүгээр хэсэг, Улсын Онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/240 дүгээр захирамжийн 2 дахь заалтын согтууруулах ундаа худалдах заалтыг хэвээр үлдээж, аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах цагийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд 08.00-20.00 цаг байхаар хязгаарлалт тогтоож, баар, караоке, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр зогсоосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг соёл, урлаг, үзвэр, үйлчилгээний газрын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн, үе шатайгаар нээхийг зөвшөөрсүгэй.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга, хяналт тавьж аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн) нарт даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100587

D:My Doc. Zahiramj. Zasag darga